



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn



ДАРГА Д.ЭРДЭНЭЧУЛУУН

2017.03.10. № 02-01/154.
танай _____-ны № _____-т

Цахилгаан эрчим хүч дамжуулах,
түгээх, хэрэглэгч байгууллагуудад
хяналт шалгалт хийх тухай.

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2017 оны хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх, хангах байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, цахилгаан эрчим хүчний тасралтгүй ажиллагаа, найдваржилт, зэрэглэлийн болон техникийн бэлэн байдалд "Төрийн хяналт шалгалтын тухай", "Эрчим хүчний тухай", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай", "Барилгын тухай" хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байгааг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлээс сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, салбарын ажил үйлчилгээний чанар, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны төлөвлөгөөт шалгалтын ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний дамжуулах, түгээх, хангах байгууллагуудын цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, техникийн бэлэн байдал, нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгчийн схемийн холболт, ажлын зураг төслийг газар дээр нь үзэж шалгана.

Шалгалтыг №5.6.2 кодтой "Цахилгаан эрчим хүч дамжуулах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас", 5.39 кодтой "Цахилгаан эрчим хүчний угсралтын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас", № 5.6.3 кодтой "Цахилгаан эрчим хүч түгээх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар шалгаж, холбогдох эрх зүйн акт, шийдвэрүүдийг гаргана.

Гурав. Шалгалтын хамрах хүрээ

Хяналт шалгалтад Нийслэлийн нутаг дэвсгэрт цахилгаан эрчим хүчний дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааг явуулж байгаа "УБТЗ"-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв, "УБТЗ"-ын Эрчим хүч ус хангамжийн 1 дүгээр анги, "УБТЗ"-ын Эрчим хүч, ус хангамжийн 2 дугаар

005050005432

анги, "УБТЗ"-ын Амгалан, Багахангай хэсэг, Цахилгаан шугам сүлжээний хэсэг, "Нолго" ХХК, "Электриком" ХХК, "Ухаалаг эрчим хүч" ХХК, "Сүлжээ" ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын 10 объектуудыг хамруулан шалгана. /Шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын нэр, шалгах улсын байцаагчдын нэрс, холбоо барих утасны жагсаалтыг хавсралтаар харуулав./

Дөрөв. Шалгалтын бүрэлдхүүн, ажлын хэсгийн ахлагч

Хяналт шалгалтыг Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч Г.Цагаанцоож ахалж, эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч М.Энхжаргал, эрчим хүчний хяналтын улсын байцаагч Б.Найрамдал, Х.Наранбаатар нар хийж гүйцэтгэнэ.

Шаардлагатай тохиолдолд бусад чиглэлийн болон эрх олгогдсон улсын байцаагчдыг татан оролцуулна.

Тав. Шалгалтын эхлэх болон дуусах хугацаа

Хяналт шалгалтыг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шалгалтын ажлыг танилцуулж, дүгнэх

1. Шалгалтын дүнг ажлын 5 өдрийн дотор хэлтсийн даргад танилцуулан, 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарах шийдвэр, санал, дүгнэлтийг холбогдох газруудад хүргүүлнэ.

2. Шалгалтын дүнгийн талаар Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан "Олон нийтэд мэдээлэл түгээх журам"-ын дагуу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

ХЯНАСАН:
ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н ГАНТУЛГА

БОЛОВСРУУЛСАН:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх, хэрэглэгч
байгууллагуудын жагсаалт

№	Аж ахуйн нэгжийн нэрс	Регистр	Холбогдох утасны дугаар	Хяналт шалгалт хийх эрчим хүчний хяналтын улсын /ахлах/ байцаагч
1	"УБТЗ" ХНН-ийн Хэрэглэгчид үйлчлэх төв	2076675	99180079	Г.Цагаанцоож
2	"УБТЗ" ХНН-ийн Амгалан хэсэг	2076675	99180079	Х.Наранбаатар
3	"УБТЗ" ХНН-ийн Багахангай хэсэг	2076675	99180079	Г.Цагаанцоож
4	"УБТЗ" ХНН-ийн Ус хангамжийн 1-р анги	2076675	99180079	М.Энхжаргал
5	"УБТЗ" ХНН-ийн Ус хангамжийн 2-р анги	2076675	99180079	М.Энхжаргал Б.Найрамдал
6	"УБТЗ" ХНН-ийн ЦШС хэсэг	2076675	99180079	М.Энхжаргал Б.Найрамдал
7	"Нолго" ХХК	2029561	99113357	М.Энхжаргал Б.Найрамдал
8	"Электриком" ХХК	2833883	99119290	Г.Цагаанцоож
9	"Ухаалаг эрчим хүч" ХХК	5173531	99115515	Х.Наранбаатар
10	"Сүлжээ" ХХК	2074729	631364	Г.Цагаанцоож